

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 дугаар
сарын 02-ний өдөр

Дугаар А-160

Улаанбаатар
хот

Үрийн улаанбуудай 2019 онд
импортлох зөвшөөрөл олгох тухай

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь хэсэг, Засгийн газрын 2013 оны 77 дугаар тогтоолоор баталсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам”-ын 3.9, 3.13 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-20 дугаар тушаал, сонгон шалгаруулах ажлын хэсгийн 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2019 онд үрийн улаанбуудай импортлох зөвшөөрлийг хавсралтад заасан аж ахуйн нэгжүүдэд олгосугай.

2. Импортлох үрийн улаанбуудайн зөвшөөрлийн талаарх мэдээллийг нийтэд болон холбогдох байгууллагад мэдэгдэхийг Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Т.Гантогтох/-т даалгасугай.

Гарын үсэг

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 05
дугаар сарын 02-ны өдрийн А-160 дугаар
тушаалын хавсралт

ҮРИЙН УЛААНБУУДАЙ 2019 ОНД ИМПОРТЛОХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР, ТОО ХЭМЖЭЭ, БТКУС КОД

№	Аж ахуйн нэгжийн нэр	Стратегийн хүнсний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	БТКУС-ын код
1	Шим ХХК	Үрийн улаанбуудай	тн	300.0	1001.11.00 1001.91.10
2	Сант-Агро ХХК	Үрийн улаанбуудай	тн	500.0	1001.11.00 1001.91.10
3	Зуун зун ХХК	Үрийн улаанбуудай	тн	80.0	1001.11.00 1001.91.10
4	Шижир болор ХХК	Үрийн улаанбуудай	тн	300.0	1001.11.00 1001.91.10
	Бүгд	Үрийн улаанбуудай	тн	1180.0	1001.11.00 1001.91.10